



TAVAN BOGD CAPITAL



БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2022 оны 9 сар

2022.12.28

БАНКНЫ САЛБАРЫН ӨСӨЛТ

- » Банкны салбарын нийт активын сүүлийн 10 жилийн дундаж өсөлт 16.94 хувь байна.
- » Хэвийн зээл 18.89 их наяд буюу нийт активын 45.56 хувийг эзлэж байна. Хэвийн зээлийн дүн өмнөх сартай харьцуулахад 0.93 хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.06 хувиар өссөн байна.
- » Аж ахуйн нэгж, иргэдийн харилцах өмнөх сартай харьцуулахад 7.91 хувиар өссөн, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 37.58 хувиар өссөн байна. Харин нийт хадгаламж өмнөх сартай харьцуулахад -1.02 хувиар буурсан, өмнөх оны мөн үетэй харьцуулахад -12.69 хувиар буурсан байна.
- » 2022 он гарснаар бодлогын хүүг 6 удаа нэмж, 13%-д хүргэсэн нь хүүгийн түвшинг цаашид үргэлжүүлэн өсгөх нь тодорхой боллоо.




Эх сурвалж: Монгол банк – Банкуудын нэгдсэн тайлан

ЗЭЭЛИЙН ЧАНАР

» 2022 оны 9 сарын 30-ны өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 22.8 их наяд хүрч өмнөх сартай харьцуулахад 0.86 хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.68 хувиар өссөн байна. Нийт зээлийн үлдэгдэлийн 20.6%-ийг бөөний болон жижиглэн худалда, машин, мотоциклийн засвар, үйлчилгээний салбарын, 14.2%-ийг үл хөдлөх хөрөнгийн салбарын зээлийн үлдэгдэл тус тус эзлэж байна.


» Хэвийн зээл 18.89 их наяд буюу нийт активын 45.56 хувийг эзлэж байна. Хэвийн зээлийн дүн өмнөх сартай харьцуулахад 0.93 хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.06 хувиар өссөн байна.

» Харин чанаргүй зээлийн хувь өмнөх сартай харьцуулахад 0.1 нэгж хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.8 нэгж хувиар өссөн байна.



Уул уурхай, олборлолтын салбарын зээлийн үлдэгдэл Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын
Барилгын салбарын зээлийн үлдэгдэл Бөөний болон жижиглэн худалда, машин, мотоциклийн засвар, үйлчилгээний салбарын
Үл хөдлөх хөрөнгийн салбарын зээлийн үлдэгдэл Бусад

• Чанаргүй зээлийн хувь




Эх сурвалж: Монгол банк – Банкчуудын нэгдсэн тайлан

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХҮҮ

Зээлийн хүү

● Шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү ● Шинээр олгосон валютын зээлийн хүү




Эх сурвалж: Монгол Банк-Сарын бюллетень

- » Шинээр олгосон төгрөгийн зээлийн хүүгийн жигнэсэн дундаж нь 14.4 хувь хүрч өмнөх сартай харьцуулахад 0.1 нэгж хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.9 нэгж хувиар өссөн байна.

Харин шинээр олгосон валютын зээлийн хүүгийн жигнэсэн дундаж нь 10.4 хувь хүрч өмнөх сартай харьцуулахад 2.8 нэгж хувиар өссөн байна.

Хадгаламжийн хүү

● Шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү ● Шинээр татсан валютын хадгаламжийн х



Эх сурвалж: Монгол Банк-Сарын бюллетень

- » Шинээр татсан валютын хадгаламжийн хүүгийн жигнэсэн дундаж нь 2.4 хувь хүрч өмнөх сартай харьцуулахад -0.1 нэгж хувиар буурсан бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.5 нэгж хувиар өссөн байна.

Харин шинээр татсан хадгаламжийн хүүгийн жигнэсэн дундаж нь 8.9 хувь хүрч өмнөх сартай харьцуулахад -0.3 нэгж хувиар буурсан бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.1 нэгж хувиар өссөн байна.


» 2022 оны 9 сарын 30-ны өдрийн байдлаар өөрийн хөрөнгө 4.0 их наяд хүрч өмнөх сартай харьцуулахад 4.24 хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.06 хувиар өссөн байна.

» Тухайн оны ашиг, алдагдал 0.7 их наяд хүрч өмнөх сартай харьцуулахад 24.95 хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 50.78 хувиар өссөн байна.


» 2022 оны 9 сарын 30-ны өдрийн байдлаар өөрийн хөрөнгийн өгөөж 19.59 хувь хүрч өмнөх сартай харьцуулахад 1.1 нэгж хувиар өссөн, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.8 нэгж хувиар өссөн байна.

» Нийт хөрөнгийн өгөөж 1.88 хувь хүрч өмнөх сартай харьцуулахад 0.1 нэгж хувиар өссөн, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.6 нэгж хувиар өссөн байна.

• Нийт хөрөнгийн өгөөж



• Өөрийн хөрөнгийн өгөөж



Эх сурвалж: Монгол банк – Банкуудын нэгдсэн тайлан


ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

» 2022 оны 9 сарын 30-ны өдрийн байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл 6.2 их наяд хүрч өмнөх сартай харьцуулахад 1.28 хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.54 хувиар өссөн байна. Нийт нийт ипотекийн зээлийн үлдэгдэлийн 0.81 хувийг ипотекийн хугацаа хэтэрсэн зээл, 0.27 хувийг ипотекийн хэвийн бус зээл тус тус эзлэж байна.

» Ипотекийн хугацаа хэтэрсэн зээл өмнөх сартай харьцуулахад 4.90 хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 109.56 хувиар өссөн байна.

» Ипотекийн хэвийн бус зээл өмнөх сартай харьцуулахад 3.44 хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад -28.58 хувиар буурсан байна.

■ Ипотекийн зээлийн үлдэгдэл




106,323

Нийт зээлдэгчийн тоо

их наяд төгрөг

6.19

Нийт зээлийн үлдэгдэл




Эх сурвалж: Монгол банк – Банкуудын нэгдсэн тайлан

БОДЛОГЫН ХҮҮ

- » Төв банкнаас арилжаалж буй хамгийн богино хугацаатай үнэт цаасны хүүг бодлогын хүү гэнэ.
- » Монголбанкны бодлогын хүүний өсөлт мөнгөний хатуу бодлогыг илэрхийлэх бөгөөд инфляцын хөөрөгдлийг бууруулах, мөнгө, зээлийн агрегатуудын хурдацтай өсөлтийг сааруулж, зохистой төвшинд байлгах, эдийн засгийн хэт халалтаас сэргийлэхэд чиглэгддэг

• Бодлогын хүү



Эх сурвалж: Монгол банк – Банкуудын нэгдсэн тайлан





ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОЛОНТ БОЛГО

БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

TBC Capital